
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Зорчилгүй дүгнэлт

“Албан журмын даатгагчдын холбоо” ГҮТББ (цаашид “АЖДХ” ГҮТББ гэх)-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Албан журмын даатгагчдын холбоо” ГҮТББ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагчдын Олон Улсын Стандарт (цаашид “СТОУС” гэх), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан журмуудын дагуу үнэн, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.

Зорчилгүй дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (цаашид АУОС гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлагчийн аудиттай холбоотой Аудиторын үүрэг хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчийн Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчийн ёс зүйн дүрэм (цаашид “НББЗОУСЗ-ын дүрэм” гэх)-ийн дагуу тус байгууллагаас хараат бус, бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд нь тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал асуудал юмаа. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг авч үзсэн ба дүгнэлт гаргахдаа эдгээр асуудлуудад тус тусад нь дүгнэлт гаргаагүй болно.

Татварын тооцооллын үнэн зөв байдал

Татварын өр төлбөрийн тооцоололт болон татварын хууль тогтоомжийн хэрэгжүүлэлт нь үнэлэмж шаарддаг учраас бид татварын тооцооллын үнэн, зөв байдлыг аудитын гол асуудал гэж үзсэн.

Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтэй холбоотойгоор Монгол улсын Засгийн газар бизнес болон эдийн засгийн бүтэцэд өөрчлөлт хийсээр байна. Үүний үр дүнд бизнесийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх хууль журмууд ч мөн өөрчлөгдөөр байна.

Эрх бүхийн өөр өөр байгууллагууд татварын хуулийн хэргэжилтэнд хяналт шалгалт хийж төлбөр торгууль тавих хуулиар тогтоосон эрхтэй байдаг. Татварын хууль тогтоомжийн ойлголт дээр үндэслэн бүх татварыг үнэн зөв тодорхойлсон гэж итгэж байгаа боловч дээр дурдсан хүчин зүйлүүдээс үндэслэн байгууллагад татварын эрсдэл байсаар байна.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (үргэлжлэл)

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээллийн талаар үүрэг хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд багтсан хэдий ч санхүүгийн тайлан ба аудиторын тайланд багтшагүй мэдээллээс бүрдэнэ.

Энэхүү санхүүгийн тайланд өгөх бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид бусад мэдээлэлд ямар нэгэн дүгнэлт өгөхгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг бэлэн болсон үед унших үүрэгтэй бөгөөд, бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитын явцад цуглуулсан мэдээллээс материаллаг хэмжээний алдаатай эсэхийг авч үзэх ёстой.

Бусад мэдээллийг уншиж, бусад мэдээлэл нь материаллаг хэмжээний зөрүүтэй эсвэл алдаатай байвал бид засаглах эрх бүхий этгээдэд мэдэгдэх үүрэгтэй бөгөөд, бид бусад горимыг гүйцэтгэж, бусад мэдээлэл материаллаг хэмжээний алдаа байгаа гэж үзсэн ба түүнийг залруулаагүй бол, залруулаагүй материаллаг хэмжээний алдааг манай тайлангийн мэдээлэл хэрэглэгчдэд хүргэхийн тулд бид зохистой арга хэмжээ авахыг засаглах эрх бүхий этгээддээ хүсэх болно.

Хэрэв бид тус байгууллагын аудитлагдсан санхүүгийн тайлан, байгууллагын орчны талаарх бидний ойлголтод материаллаг хэмжээний алдаа байна гэж үзвэл, бид АОУС-ын дагуу холбогдох арга хэмжээ авна.

Санхүүгийн Тайлантай холбоотой Удирдлага болон Засаглах Эрх Бүхий Этгээдийн Үүрэг

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэн шударгаар илэрхийлэх, санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний алдаагүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ байгууллагыг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд удирдлага байгууллагын үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжыг үнэлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг шингэлэн санхүүгийн тайланг бэлтгэх үүрэгтэй.

Засаглах эрх бүхий этгээд нь тус байгууллагын санхүүгийн тайлангийн үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Аудиторын үүрэг

Санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа, эсвэл санаатай зальт үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар үл үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь байнга материаллаг хэмжээний алдааг илэрүүлдэг гэсэн баталгаа болохгүй. Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай зальт үүдлээс үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.



АУДИТ
БАТАЛГААНГУУЛАЛТ
ҮЙЛЧИЛГЭЭ

Монголын Бизнес Рейтинг Аудит ХХК
УБ, Баянзүрх дүүрэг, 6-р хороо
Баруунд МН ХХК-ийн нэвтрэлт 303
Утас: 976 1000-5329
Гар утас: 976-9985-3823
И-мэйл: mbr.audit.16@gmail.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (үргэлжлэл)

Тайлангийн хэрэгтэй

Бид энэхүү тайланг хуулийн этгээд болох "Албан журмын даатгагчдын холбоо" ГҮТББ –ын удирдах зөвлөлд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр алмаа нэг гуравдагч талын өмнө харууцлага хүлээхгүй.



Д.Түмэнжаргал Ерөнхий захирал,
Монголын Бизнес Рейтинг Аудит ХХК
Улаанбаатар хот, Монгол Улс

Огноо: 2018.02.05

"АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧИДЫН ХОЛБОО" ГҮТББ
 2017 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон тайлант жил
 САНХҮҮ БАЙДЛИЙН ТАЙЛАН

	Тодот гол	2017.12.31 (төгрөг)	2016.12.31 (төгрөг)
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө		-	-
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө		2,659,474,921.83	70,134,639.56
Богино хугацаат хөрөнгө оруулалт		9,968,301,160.62	6,954,668,629.83
Авлага		171,269,487.00	2,209,143,661.55
Бараа материал		6,695,619.00	16,184,669.00
Урьдчилж төлсөн зардал/гооцоо		161,392.00	5,257,040.00
Эргэлтийн хөрөнгийн дүн		12,805,902,580.45	9,255,388,639.94
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө		398,182,862.50	528,502,563.14
Биет бус хөрөнгө		458,226,762.03	191,503,242.01
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		856,409,624.53	720,005,805.14
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		13,662,312,204.98	9,975,394,445.08
ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ			
Богино хугацаат өглөг		-	-
Дансны өглөг		-	8,108,017.32
Цалингийн өглөг		12,701.01	472,937.79
Татаар хураамжын өр		-	71,443.79
Бусад өглөг		1,080.41	238,774.00
Урьдчилж орсон орлого		-	1,000,000.00
Богино хугацаат өглөгийн дүн		13,781.42	9,891,172.90
Өр төлбөрийн дүн		13,781.42	9,891,172.90
Цэвэр хөрөнгө:			
Нөөц: а) Хязгаарлалтгүй		10,000,000.00	10,000,000.00
б) Хязгаарлалттай		13,630,356,898.58	9,937,760,891.20
Хуримтлагдсан үр дүн		-	-
Тайлант үеийн		21,941,524.98	17,742,380.98
Өмнөх үеийн		-	-
Эздийн өмчийн дүн		13,662,298,423.56	9,965,503,272.18
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧИЙН ДҮН		13,662,312,204.98	9,975,394,445.08

Эдгээр санхүүгийн тайлант холбогдох тодруулгын хамтаар уншина уу.

"АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧУДЫН ХОЛБОО" ГҮТББ
 2017 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон тайлант жил
 ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

	Төлөт гол	2017.12.31 (төгрөг)	2016.12.31 (төгрөг)
Үндсэн үйл ажиллагааны орлого		4,826,923,799.28	3,911,936,512.85
Үндсэн үйл ажиллагааны зардал		1,134,327,791.90	1,448,043,384.78
Үндсэн үйл ажиллагааны үр дүн		3,692,596,007.38	2,487,555,843.07
Үндсэн бус үйл ажиллагааны орлог		4,199,144.00	178,776.00
Үндсэн бус үйл ажиллагааны алдагдал		4,199,144.00	178,776.00
Тайлант үеийн швэр үр дүн		3,696,795,151.38	2,487,734,619.07

Эдгээр санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.

"АЛБАН ЖУРМЫН ДАЛГАГЧДЫН ХОЛБОО" ГҮТББ
 2017 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон тайлант жил
 ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(төгрөг)

	Хязгаарлалт гүй нөөц	Хязгаарлалт тай нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт
2016 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	10,000,000.00	9,937,760,891.20	17,742,380.98	9,965,503,272.18
НБББ-ын өөрчлөлтийн нөлөөлөл, алдааны залруулга				
Залруулсан үлдэгдэл	10,000,000.00	9,937,760,891.20	17,742,380.98	9,965,503,272.18
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				
2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	10,000,000.00	9,937,760,891.20	17,742,380.98	9,965,503,272.18
НБББ-ын өөрчлөлтийн нөлөөлөл, алдааны залруулга				-
Залруулсан үлдэгдэл				
Тайлант үеийн үр дүн (алдагдал)		3,692,596,007.38	4,199,144.00	3,696,795,151.38
2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	10,000,000.00	13,630,356,898.58	21,941,524.98	13,662,298,423.56

Эдгээр санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.

"АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО" ГҮТББ
2017 он 12 сарын 31-ний өдөрөөр тасалбар болсон тайлант жил
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	2017.12.31 (төгрөг)	2016.12.31 (төгрөг)
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	2,209,843,573.58	2,744,405,632.54
Гишүүдийн татвараас орсон мөнгө	15,000,000.00	14,000,000.00
Даатгалын сангийн орлого	6,079,975,263.86	2,467,646,028.91
Бусад мөнгөн орлого	171,000.00	262,759,603.63
Мөнгөн зарлагын дүн (-)	981,361,618.40	1,469,919,625.73
Ажилчдад төлсөн	381,252,423.00	596,377,059.79
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	95,037,873.00	139,389,448.48
Бараа материал худалдан авахад төлсөн	8,701,451.00	14,086,179.00
Ашиглалтын зардалд төлсөн	219,172,954.70	233,054,522.12
Түлц, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	22,479,758.00	35,393,922.00
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө	138,429,670.08	230,055,683.15
Татварын байгууллагад төлсөн	41,753,827.00	64,433,271.19
Даатгалын төлбөрт төлсөн	74,533,661.00	157,129,540.00
Бусад мөнгөн зарлага	-	-
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,357,984,916.079	(1,918,232,415.36)
Хөрөнгө оруулалтын ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Худалдсан урт хугацаат хөрөнгийн орлого	14,595,888.00	
Худалдаж авсан урт хугацаат хөрөнгө	(358,948,274.00)	(163,556,500.00)
Худалдаж авсан хөрөнгө оруулалт	(3,013,632,530.79)	(1,754,675,915.36)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,357,984,916.079	(1,918,232,415.36)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	833,540,553.60	518,692,385.94
Банкнаас авсан зээл /НТ-ийн төлөлт/		-
Зээлийн төлөлт /НТ-ийн олголт/		-
Хүү ба урамшуулалын орлого	833,540,553.60	518,692,385.94
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	833,540,553.60	518,692,385.94
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	2,589,340,282.27	(125,054,022.61)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	70,134,639.56	195,188,662.17
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,659,474,921.83	70,134,639.56

Эдгээр санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.